



# СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№71 /515/

2023.05.02

Цаг үе, үйл явдал

## ЭНХИЙГ САХИУЛАГЧИД ШАРХАДСАН ЦЭРГИЙН АЛБА ХААГЧДЫН АМИЙГ АВАРЛАА



Монгол Улсын Зэвсэгт хүчний 12 дугаар ээлжийн мотобуудлагын батальоны үүрэг гүйцэтгэж буй БНӨСУ-д явагдаж байгаа UNMISS ажиллагааны "Юнити" секторт үерийн гамшгийн улмаас аймаг, сумдыг холбосон үндсэн хангалтын замууд усанд автан, хөдөлгөөн хаагдаж хүнсний хомсдолоос үүдэлтэй малын хулгай, дээрэм, дэлхийн хүнсний хөтөлбөрийн цуваа руу халдах зэрэг гэмт хэргийн гаралт нэмэгдэж байгаа нь цагийн байдлыг тогтворгүй болгож байна.

Тодруулбал 4 дүгээр сарын 27-ны өдөр Бентью суурингаас Майом суурин руу эргүүлийн үүрэг гүйцэтгэж явсан Монгол Улсын Зэвсэгт хүчний

12 дугаар ээлжийн бүрэлдэхүүн Майом суурингаас хойш 35 километр байрладаг Кайкан суурингийн зам дээр болсон зэвсэгт халдлагын улмаас Бүгд Найрамдах Өмнөд Судан Улсын Ардын Чөлөөлөх Арми /Сөрөг хүчний (SPLA-IO)-ийн цэргүүдээс нэг цэрэг нь амь үрэгдэж, хоёр цэрэг шархадсан байсантай таарсан байна.

Тэд энэхүү эргүүлийн бүлгээс тусламж хүссэний дагуу шархадсан цэргийн алба хаагчдад анхан шатны тусламжийг үзүүлэн Бентью суурингийн төв эмнэлэгт хүргэх ажиллагааг зохион байгуулсны үр дүнд тэдний амь насыг авран хамгааллаа.

Ахлах дэслэгч Л.ТҮМЭНДЭЛГЭР

## МАРАФОН ГҮЙЛТИЙН УЛСЫН АВАРГАД АМЖИЛТ ДҮҮРЭН ОРОЛЦЛОО

"Багахангай марафон-2023" улсын аварга шалгаруулах тэмцээн 4 дүгээр сарын 30-ны өдөр Багахангай дүүрэгт зохион байгуулагдаж, Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн алба хаагчид амжилт дүүрэн оролцов. Монголын хэт холын марафон гүйлтийн холбоо, Багахангай дүүргийн ЗДТГ-аас 12 дахь жилдээ хамтран зохион байгуулсан улсын аваргын марафон гүйлтийн тэмцээнд Монгол Улс, АНУ, Япон, Нидерланд, Киргиз зэрэг 5 орны тамирчин өрсөрсөн үе болон насанд хүрэгчид гэсэн төрөлд өрсөлдсөн юм.

Нийтдээ 15 аймаг, 6 дүүргийн төлөөлөл буюу 44 байгууллага, клубын 500 гаруй тамирчин тэсвэр хатуужил, хурд хүчээ сорин өрсөлдсөнөөс насанд хүрэгчдийн 10 км зайд Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн артиллерийн дивизионы Хангалт үйлчилгээний салааны нярав, Олон улсын хэмжээний мастер, ахлагч Б.Мөнхзаяа алтан медаль, 50 км зайд тус ангийн мотобуудлагын батальоны хангалт

үйлчилгээний салааны нярав, Олон улсын хэмжээний мастер, дэд ахлагч Б.Сарангуа мөнгөн медаль тус тус хүртсэн бахдам амжилт үзүүлэв. Ахлагч Б.Мөнхзаяа 5, 10, 21, 42 км зайд улсынхаа дээд амжилтын эзэн бол дэд ахлагч Б.Сарангуа эх орныхоо 12 цагийн гүйлтийн рекорд эзэмшигч бөгөөд 2018 оны улсын аваргын хүрэл, 2019 оны мөнгөн медальт тамирчин юм.

Мөн Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн холбооны албаны залгагч, Олон улсын хэмжээний мастер, Монгол Улсын 24 цагийн гүйлтийн рекорд эзэмшигч Г.Уугантуяа тус тэмцээний буюу төрөлд Хилийн цэргийн 0132 дугаар ангийн тамирчидтай хамтран оролцож, тусгай байрт шалгарсан байна. Г.Уугантуяа нь 2018 онд Тайваньд зохион байгуулагдсан 24 цагийн марафон гүйлтийн Азийн аварга шалгаруулах тэмцээнд Монгол Улсын рекордыг шинэчлэн тогтоож чадсан Зэвсэгт хүчний ажилтан албан хаагч юм.



### ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 9	☁️ 0

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 36	☁️ 26

### ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,467	3,472
EUR 🇪🇺	3,820	3,840
CNY 🇨🇳	500	502.30
RUB 🇷🇺	42	42.40
JPY 🇯🇵	25.50	25.90
KRW 🇰🇷	2.57	2.59

### ЗУРХАЙ

2023.05.02 /МЯГМАР ГАРАГ/  
БИЛГИЙН ТООЛЛЫН 12

ХАВРЫН АДАГ УЛААН ЛУУ  
САР  
ХОЁР ХАР МЭНГЭТЭЙ ЦАГААН  
БИЧ ӨДӨР

Үс засуулбал:  
Өвчин эмгэг ирнэ  
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:  
05.35-20.04  
Барилдлага:  
Хүчин төгсөх  
ШҮТЭН БАРИЛДЛАГА:  
Тийн мэдэхүй

Тухайн өдөр могой, морь, гахай, хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян үйл үйлдвээс өлзийтэй, өргөл хүндлэл, бурханд соёрхол тавих, амирлуулах, дэлгэрүүлэх, эрхшээх үйл нигууд бүтээхэд сайн, эм засал хийлгэх, авшиг авах, бэрийн үйл, дайсныг дарахад болон хуран чуулах, үс угаахад сайн. Зүүн нүд татвал хувцас олдох, баруун нүд татвал тэмцэл болох, баруун чих хангинавал сайн, зүүн нь хангинавал өчүүхэн нэгнийг үзэх, тагнай загатнах, бие татвал үзэсгэлэн болох, хөлийн шөрмөс татвал үг, асуулт болно.

## ХИЛИЙН ЦЭРГИЙН АЛБА ХААГЧ УХААН АЛДСАН СУРАГЧИЙН АМИЙГ АВАРЧЭЭ




Сонгинохайрхан дүүргийн 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт Цамбагарав орчимд байрны гадаа ухаан алдаж, амьсгал нь зогсонги байдалд орсон Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид хилийн цэргийн офицер цаг алдалгүй анхны тусламж үзүүлэн амь насыг нь аварлаа.

Тусламж үзүүлэх явцад иргэний амьсгал нь 20 гаруй удаа

зогссон ба яаралтай тусламж үзүүлэн эмнэлгийн байгууллагад хүлээлгэн өгсөн байна.

Тэрбээр Хилийн цэргийн 0267 дугаар тусгай салбарын алба хаагч юм. Өнөөдөр орон даяар ХЦАХ-д халагдаж байгаа төдийгүй, албаа үлгэр жишээч хаасан байлдагч, түрүүчийнхээ ар гэрт талархал илэрхийлэхээр явах замдаа ийнхүү хүний амь аварлаа.



## "UNMISS" АЖИЛЛАГААНЫ ХҮЧНИЙ КОМАНДЛАГЧ МОНГОЛ УЛСЫН ЦЭРГИЙН БАГТ



БНӨСУ-д явагдаж дэслэгч генерал Мохан буй НҮБ-ын энхийг дэмжих "Юнити" секторын командлагч Хүчний командлагч бригадын генерал

Эммануэль Ругазора болон албаны бусад бүрэлдэхүүн 4 дүгээр сарын 27-ны өдөр "Хубилай" баазад айлчилж, Монгол Улсын Зэвсэгт хүчний 12 дугаар ээлжийн цэргийн багийн үйл ажиллагаатай танилцлаа.

Хүчний командлагч дэслэгч генерал Мохан Субраманийг мотобуудлагын батальоны Хүндэт харуул жагсаж, угтсаны дараагаар тус батальоны үүрэг гүйцэтгэлтийн талаарх танилцуулгыг хурандаа Н.Эрдэнэбаяр хийсэн юм. Энэ үеэр албаны бүрэлдэхүүн мотобуудлагын батальоны хүндэтгэлийн танхимд зочлон хүндэт дэвтэрт санал, сэтгэгдэлээ үлдээсэн бөгөөд баазын дотоод үйл ажиллагаатай биечлэн танилцсан юм.

Хүчний командлагч дэслэгч генерал Мохан Субрамани "Хүндэт зочны дэвтэр"-т үлдээсэн сэтгэгдэлдээ "Монгол Улсын Зэвсэгт хүчний 12 дугаар ээлжийн цэргийн багийн бие бүрэлдэхүүн нь үүрэг гүйцэтгэж буй Юнити муж болон Бор

сууринд өөрсдийн цэргийн эрдэмд мэргэшсэн байдал, сахилга, зохион байгуулалтын өндөр түвшинд, эрэмгий байдал, ур чадвараараа UNMISS ажиллагааны цэргийн хүчний хэмжээнд жишиг тогтоож, мэргэжлийн ур чадвараараа үлгэр жишээ болж байгааг хэлэхэд таатай байна. Монгол Улсын цэргийн багийн бүрэлдэхүүнд 93 эмэгтэй цэргийн алба хаагч үүрэг гүйцэтгэж байгаа нь ажиллагааны хэмжээнд тоогоороо бусад улсуудын цэргийн багаас тэргүүнд эрэмблэгдэж байгаа бөгөөд тэдний төлөөлөлтэй уулзаж үүрэг гүйцэтгэх хугацаанд олж авсан цэргийн хэргийн мэдлэг, туршлагын талаар санал солилцох боломж олдсон сайхан уулзалт боллоо. Хурандаа Н.Эрдэнэбаяр захирагчтай Монгол Улсын цэргийн багийн бие бүрэлдэхүүнд UNMISS ажиллагааны цэргийн хүчний гол цөм болж байгаад нь талархаж, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе" гэж тэмдэглэсэн байна.

Ахлах дэслэгч Л.ТҮМЭНДЭЛГЭР

### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 687,225,609

Эдгэрсэн

Нийт: 659,731,745

Нас барсан

Нийт: 6,866,733

Цахим шууданд

БУСДЫН АМЬ НАСЫГ АВАРСАН ДАЙЧДАА ОНЦЛОХУЙД ...



Дэлгэрхаан сумынхаа эмнэлэг, цагдаагийн байгууллагад яаралтай мэдэгдсэн. Одоо хоёр иргэн ухаан орж, биеийн байдал нь дээрдэг байгаа тухай сумын эмч нараас ангийн удирдлагад хэлсэн байна лээ. Яаралтай арга хэмжээг цаг алдалгүй авсан дайчдаа баярлалаа гэдгийг заавал хэлээрэй гэж дамжуулсан байсан. Осолд өртсөн хоёр иргэн нь Дэлгэрхаан сумын малчид” гэсэн мэдээллийг өглөө.

Зам тээврийн ноцтой осолд өртсөн иргэдэд цаг алдалгүй тусламж үзүүлж, амь насыг нь аварсан дайчдын тухай танилцуулахад дэслэгч Н.Бумбаяр нь Ховд аймгийн Манхан сумынх. 2011-2017 онд “Тэмүүжин-Өрлөг” дунд сургуулийг Г.Наранчимэг багшийн удирдлагад, 2017-2022 онд ҮБХИС-ийн ЦНДС-ийн Ерөнхий цэргийн командын офицер мэргэжлээр дэд хурандаа Л.Сэрж-Очир багшийн удирдлагад тус тус суралцаж төгссөн. 2022 оноос Зэвсэгт хүчний 232 дугаар ангиас салааны захирагчаар ажлын гараагаа эхлүүлсэн залуу офицер юм.

Сургагч ахлагч Б.Ганбаяр нь 2000 онд ҮБХИС-ийн Ахлагч бэлтгэх төвийг дүүргэж, ажлын гараагаа Зэвсэгт хүчний 150 дугаар ангиас буудагчаар эхлүүлсэн нэгэн. Үүний дараа ҮБХИС-ийн Ахлагчийн сургуульд дамжааны багш, Зэвсэгт хүчний 032 дугаар ангид салааны ахлагчаас ажиллагааны ахлагч болтлоо дэвшин ажиллаж, 2022 оноос Зэвсэгт хүчний 232 дугаар ангийнхаа эгнээнд нэгджээ. Зэвсэгт хүчинд 24 дэх жилдээ алба хааж байгаа тэрээр Хэнтий аймгийн Биндэр сумынх бөгөөд цэрэгжлийн спортын шилдэг тамирчдын нэг.

Цагийн манаачаар үүрэг гүйцэтгэхдээ сонор сэрэмжтэй байж, аюул ослын талаар яаралтай мэдээлэл хүргэсэн байлдагч Г.Өнөболд Төв аймгийн Зуунмод сумынх. Хугацаат цэргийн албанд татагдан ирэхээс өмнө СУИС-д кино телевизийн зураглаач мэргэжлээр суралцаж байсан, гуравдугаар дамжааны оюутан. Оюутныхаа хугацаанд олон киноны арын албанд ажилласан туршлагатай гэнэ. “Богд хаан II” уран сайхны киноноос эхлээд олон бүтээлд туслахаар ажилласнаа онцолж байв. Тэрээр аав Э.Ганболд, ээж С.Дэлгэржаргал, ах эгч, дүү нартаа албандаа сайн яваагаа уламжилж, морьтон дайчин болсондоо бахархаж явдгаа илэрхийллээ. Цэргийн албаа нэр төртэй хаасныхаа дараа мэргэжлээрээ үргэлжлүүлэн суралцаж, тайз, дэлгэцийн олон олон бүтээлийг зураглах нь түүний ойрын зорилго ажээ.

Ахмад Д.БОЛОР

“Морьтон дайчид” гэдгээрээ алдаршсан Зэвсэгт хүчний 232 дугаар ангийн салааны захирагч, дэслэгч Н.Бумбаяр, салааны ахлагч, сургагч ахлагч Б.Ганбаяр, байлдагч Г.Өнөболд нар жижүүр, харуулын үүрэг гүйцэтгэх үедээ бусдын амь насыг аварсан баатарлаг үйлс байгууллаа. Энэ талаар дэслэгч Н.Бумбаяр “4 дүгээр сарын 29-ний шөнө 01 цагийн үед цагийн манаачаар үүрэг гүйцэтгэж байсан байлдагч Г.Өнөболд ангийн байрлалаас 200 метрийн зайд автомашин осолдсон юм шиг байна. Гэрэл нь асаатай байна” гэж мэдэгдсэний дагуу яаралтай очиж шалгахад хоёр эрэгтэй хүн ухаангүй, зам тээврийн томоохон осол гарсан байдалтай байсан. Тэгэхээр нь машинаас нь зөөлхөн өргөж гаргаад цусыг нь тогтоож, анхан шатны тусламж үзүүлсэн. Мөн Хэнтий аймгийн

БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖИЛД ГАРАХ ҮЕИЙН ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГУУЛАВ



Зэвсэгт хүчний Тээврийн хяналтын албанаас Барилга-инженерийн цэргийн удирдах газрын харьяа ангиудыг “Богдхан” төмөр замын төслийн ажлын талбайгаас Гашуунсүхтэй боомтын “Автомат удирдлагатай чингэлэг тээврийн терминал байгуулах төсөл”-ийн ажлын талбайд нүүлгэн шилжүүлэх тээвэрлэлтийг зохион байгуулах үеийн замын хөдөлгөөний аюулгүй байдал хангуулан ажиллаа.

СУРГАЛТ, НӨЛӨӨЛЛИЙН АЖЛЫГ ШИНЭ АРГА БАРИЛААР ҮР ДҮНТЭЙ ЗОХИОН БАЙГУУЛАХЫГ ЗАХИЛАА

Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагч бригадын генерал Ч.Цогтжаргал Хуурай замын цэргийн нэгтгэл, ангиудын удирдах бүрэлдэхүүнд 5 дугаар сарын 2-ны өдөр тодорхой асуудлаар үүрэг чиглэл өглөө.

Хаврын тариалалт түүний бэлтгэл ажил хангагдсан эсэх, замын хөдөлгөөний болон хөдөлмөрийн аюулгүй байдал, ажлын цаг ашиглалт, алба хаагчдын үр бүтээмжтэй байдал зэрэг хэд хэдэн асуудлаар үүрэг өгч, харилцан ярилцав. Тухайлбал, хаврын тариалалт эхэлж байгаатай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн болон Хуурай замын цэргийн нэгтгэл, ангиудад хэрэгжиж байгаа “Хүний хөгжлийн эко, ногоон орчинг бүрдүүлье” төслийг хэрхэн хэрэгжүүлэх тухай онцлов. Ойжуулалт, зүлэгжүүлэлт, ногоон байгууламжийг мэргэжлийн хүмүүсээс нь зөвлөгөө авах замаар гүйцэтгэхийг дурдаж, замын хөдөлгөөн, хөдөлмөрийн аюулгүй байдалд захирагчаасаа түрүүч, байлдагч хүртлээ онцгой анхаар гэв. Орон нутгийнхаа цагдаагийн алба хаагчидтай хамтран замын хөдөлгөөний аюулгүй байдлын сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг



шинэ арга барилаар үр дүнтэй зохион байгуулахыг сануулав. Мөн хөдөлмөрийн аюулгүй байдлын зааварчилгааг ажил алба гүйцэтгэх бүх цаг хугацаандаа баримталж, техникийн бүрэн бүтэн байдал хангаагүй автомашиныг тээвэрт гаргахгүй байдлыг хатуу анхаарууллаа. Төгсгөлд нь алба

хаагчид өдрийн хамгийн идэвхтэй цаг үеийг ажлын байран дээр өнгөрүүлдэг. Ажлын орчин гэдэг ээлтэй, ая тухтай, сэтгэл зүйн дарамтгүй байх ёстойг онцолж, алба хаагчдын үүрэг гүйцэтгэлтийг урамшуулах, дэмжих, хөгжүүлэх, сургах замаар дээшлүүлэхийг захилаа.

”МОНГОЛ БИЧГИЙН ХЭРЭГЦЭЭ” ӨДӨРЛӨГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Монгол Улсын үндэсний үргэлжлэл Өвгөн буурал сургаал бичиг мину бичиг үсэг, эх хэл, түүх, өв соёлыг хугацаат цэргийн алба хаагчдаа сурталчилсан соёл хүмүүжлийн арга хэмжээг Зэвсэгт хүчний 326 дугаар ангиас тасралтгүй зохион байгуулдаг билээ.

Энэ удаа “Монгол бичгийн хэрэгцээ” өдөрлөгийг 4 дүгээр сарын 30-ны өдөр зохион байгуулж, уйгуржин бичгээ сэргээн хэрэглэх төрийн бодлогыг сурталчиллаа

Өдөрлөгөөр түрүүч, байлдагч нар алдаагүй зөв бичих, цэвэр сайхан бичих, уран бичлэгээр өрсөлдөхийн зэрэгцээ шүлэг зохиосон бөгөөд тэргүүн байрт дэд түрүүч Б.Бүдбаатар, дэд байрт байлдагч О.Оргил, гутгаар байрт байлдагч Б.Рагчаасүрэн нарын бүтээл шалгарч, өргөмжлөл үнэ бүхий зүйлээр шагнагдсан юм.

Тэргүүн байрт шалгарсан дэд түрүүч Б.Бүдбаатарын “Өвгөдийн мөр, түүхийн гэрч” шүлгийг толилуулья. Дэлхийн түүхэнд мөртэй

Дээдсийн ариун шаштир мину Өнөөг хүртэл оршсон түүхийн

Хүслийн үзүүрт гэрэлтсэн хөх монгол бичиг минь Хүннү гүрнээс угсаатай эх орон минь Хүлэг морьдын төвөргөөнтэй эх нутаг минь Хүлгийн дэлнээс зүүгдсэн Хүннү ургийн бичээс Хүслийн үзүүрт гэрэлтсэн хөх монгол бичиг минь Туугдсан салхинд тушаатай байсан монгол бичиг Тусгаар тогтнолоо зарлахад туг шиг дэрвэсэн монгол бичиг Өвөг дээдсийн үлдээсэн өндөр их өв соёл Үр хойчдоо үлдээх үнэлшгүй их эрдэнэс Ард олны замыг гэрэлтүүлсэн амьд босоо бичиг Ариун тамгатай алдарт босоо монгол бичиг Эзэн богд Чингис хааны шидээр амилсан Эх орны минь оюуны тусгаар тогтнол босоо монгол бичиг минь

Дэслэгч 3.ӨСӨХБАЯР

СУРГАЛТ ХИЙЖ, МЭДЭЭЛЭЛ ӨГЛӨӨ



Зэвсэгт хүчний Тээврийн хяналтын албаны даргын орлогч тээврийн хяналтын ахлах

зохицуулагч хошууч М.Мөнхбаяр, ДХИС-ийн багш цагдаагийн хошууч Т.Анхбаяр нар Зэвсэгт хүчний Кибер аюулгүй байдлын цэргийн командлал, Барилга-инженерийн цэргийн удирдах газар, Тусгай хүчний цэргийн командлал, Агаарын цэргийн командлал, Зэвсэгт хүчний 303 дугаар анги болон Төрийн өмчит үйлдвэрийн газрын алба хаагчдад “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдвээр сургалт хийж, мэдээ мэдээлэл өглөө.

“АЛДАР”-ЫН БӨХЧҮҮД ӨНГӨЛӨВ



Монгол Улсад Шинжлэх ухааны мал эмнэлэг, үржлийн алба үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойд зориулсан Улс, аймгийн алдар цолтой 256 бөхийн барилдаанд Өвөрхангай аймгийн Төгрөг сумын харьяат, “Алдар” спорт, “Их Монголын хүчтэн” дэвжээний бөх, улсын харцага Цэдэнсодномын Бямба-Отгон түрүүлж, Хөвсгөл аймгийн Их-Уул сумын харьяат, Сүлд спорт хороо, “Хөвсгөлийн хүчтэн” дэвжээний бөх, улсын начин Батбаярын Даваа-Очир үзүүрлэв.

Дөрөвт Ховд аймгийн Зэрэг сумын

харьяат, Алдар спорт хороо, Ховд дэвжээний бөх, улсын заан Б.Бат-Өлзий, Архангай аймгийн Хайрхан сумын харьяат, “Алдар” спорт хороо, “Бөхбилэгт” дэвжээний бөх, улсын харцага О.Мөнх-Эрдэнэ нар шалгарлаа.

Наймд улсын арслан Р.Пүрэвдагва, улсын харцага Б.Зоригтбаатар, Ц.Мөнхбаяр, аймгийн арслан Б.Өсөхбаяр нар үлдэв.

Дэд хурандаа Т.ӨСӨХ-ИРЭЭДҮЙ